

Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Равдан Цэдэв

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.							
1	Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулах,	сургалт арга хэмжээ зохион байгуулсан байна.	2 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулж ажилласан.	1 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулсан байна.	Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих PROGRESS төсөлтэй хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд “Брэндийг хэрхэн бүтээх вэ?” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад 25 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, Брэнд бүтээгдэхүүнийг бий болгоход ямар шат дамжлагаар явдаг, хэрхэн бүртгүүлж оюуны өмч болгодог талаар мэдлэг мэдээлэл олж авсан.	5-р сар, 6-р сар	100%

					Энэхүү сургалтын үр дүн дээр тулгуурлан брэнд бүтээгдэхүүний шалгуур хангахуйц 8 аж ахуйн нэгжид мэргэжлийн багшийн ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг үзүүлж ажилласан. Брэндийн сургалт, зөвлөх үйлчилгээн дээрээ түшиглэн бэлгийн багцын уралдаан зарлаж шалгаруулан хөнгөн үйлдвэрийн салбараас 2 аж ахуйн нэгж, хүнсний үйлдвэрийн 3 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн шалгарч сав баглаа боодлын асуудлыг шийдэх нийт 10,0 сая төгрөгийн урамшуулал олгосон.		
2	Оёдлын үйлдвэр, эрхлэгчдийг чадавхижуулах сургалт арга хэмжээ зохион байгуулах	Сургалт зохион байгуулж чадавхижуулсан байна.	2 удаагийн чадавхижуулах сургалт зохион байгуулсан.	1 удаагийн сургалт зохион байгуулсан байна.	USAID-н санхүүжилттэй "Хөгжлийн Шийдэл" ТББ-н хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр нь "Эрдэнэтийн оёдолчдын холбоо" ГҮТББ хамтран Оёдлын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Зорилго: Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа оёдлын бизнес	3-р сар, 4-р сар	100%

					эрхлэгч бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч нарт бизнесээ хөгжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээгээр дамжуулан чадавхижуулж бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулах, зээл авах боломжийг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. Оёдлын салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах зорилгоор "Засаглалын тухай ерөнхий ойлголт", "Бизнес төсөл хэрхэн боловсруулах вэ?" "Монгол хувцасны эсгүүр, технолгогийн сургалтуудыг зохион байгуулж, Банк санхүүгийн байгууллагатай хамтран банкуудын зээлийн мэдээллийг хүргэлээ. Сургалтанд давхардсан тоогоор 200 хүнийг хамруулаад байна.		
1.2. Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний салбарыг санхүүгийн болон санхүүгийн бус хэлбэрээр дэмжин ажиллах							
3	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа,	борлуулалтыг дэмжин ажиллах	3 удаагийн үзэсгэлэн худалдаанд 150	2 удаагийн үзэсгэлэнд оролцуулсан	Сайхан шинэлээрэй", Амар байна уу?, "Монгол сар, Монгол	1-р сар, 2-р сар, 10-р сар	100%

	бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаанд оролцуулах		гаруй үйлдвэрлэгчдийг оролцуулсан	байна.	бэлэг” “ Цагаан сар-2024” зэрэг үзэсгэлэн худалдаанд 110 аж ахуйн нэгж оролцсон. Зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн худалдааны мэдээллийг орон нутгийн болоод ойролцоох аймаг, сумдын хэрэглэгчдэд хүргэж ажилласны үр дүнд: уг арга хэмжээг нийт 450 гаруй хүн үзэж сонирхон 500 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээс худалдан авалт хийсэн байна.		
4	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах.	зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	32 аж ахуйн нэгжид 1,5 тэрбум төгрөгийн зээл олгосон.	Зээлд хамрагдсан байна.	ХХААХҮ-ийн сайдын А/28 дугаар тушаалаар баглагдсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн зориулалтаар Орхон аймагт 1,0 тэрбум төгрөг баглагдсан. 21 салбар, чиглэлд үндсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зориулалтаар 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй, үндсэн төлбөрөөс 1 жил хүртэл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

					чөлөөлөх нөхцөлөөр олгож байна. Төслийг хуанлын 30 хоногийн хугацаанд цахим систем ашиглан, 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 8 төсөл хүлээн авч өнөөдрийн байдлаар 3 шатны судалгааны ажил хийгдэн дэд хорооны хурлаар 674,0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 4 төслийг хэлэлцэн шийдвэрлэж, жагсаалтыг аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн.		
2.1. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлэх аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг хангах							
5	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлэх аж ахуйн нэгжид тавигдах шаардлагын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, тодорхойлолт олгох	Жижиг дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгч тодорхойлолт олгосон байна.	2023 онд нийт 150 гаруй аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч, 65 аж ахуйн нэгжид тодорхойлолт олгосон байна.	зөвлөгөө мэдээлэл өгч тодорхойлолт олгосон байна.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээл зарласантай холбогдуулан мөн зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа, тендер гэрээний бүрдүүлэх материалтай холбогдуулан 2 удаагийн сургалт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					зохион байгуулж жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр хэрхэн бүртгүүлэх, ямар материал бүрдүүлэх, системээс хэрхэн татаж авах талаарх мэдээллийг өгч гарын авлагаар ханган ажилласан. Нийт 50 аж ахуйн нэгжийн төлөөлөлд мэдээлэл зөвлөгөө өгч 43 аж ахуйн нэгжийг жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгэж тодорхойлолт олгосон.		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
6	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар, улирал, хагас, бүтэн жилээр боловсруулан гаргаж, батлуулан ажиллаж байна. - Төлөвлөгөөний биелэлтийг сар бүр гаргаж, баталгаажуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. - Хариуцсан салбаруудтай холбоотой бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцан ажиллаж байгаа салбартай холбогдон гарсан хууль тогтоомжийн өөрчлөлтийг судлан бүхий л чиглэлээр өөрийгөө хөгжүүлэн суралцана.	Холбогдох сургалтуудад хамрагдах	3 удаагийн сургалтанд амжилттай оролцож Батламж гэрчилгээтэй төгссөн.	Холбогдох сургалтуудад хамрагдах	Хариуцсан салбарын хүрээнд ахиц дэвшил гаргаж өөрийгөө хөгжүүлэх зорилгоор 3 удаагийн сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлээ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Равдан Цэдэв /...../

Огноо: 2024.06.10